

АХМАД НАСТНУУДАД УЧИРЧ БУЙ ДАРАМТЛАЛ, ХҮЧИРХИЙЛЭЛ

Ж.Алтанцэцэг, Хүчирхийллийн Эсрэг
Үндэсний Төвийн Тэргүүн

“Ахмад настнуудад учирч буй дарамтлал, хүчирхийлэл” сэдэвт судалгаа нь Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Монголын Ахмадын Холбоо хамтран Зохиистой Хөгжлийн Жендэр Төвийн судлаачдын оролцоотойгоор “Монгол Улсад Хүний Эрхийг Хангах Төсөл”-ийн хүрээнд 2002 оны 10-р сард хийгдсэн юм. Судалгаанд Улаанбаатар хот, хөдөөгийн нийт 1000 ахмад настнууд хамрагдсан болно. Судалгааны гол зорилго нь “Гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн төслийг 2003 онд УИХ-аар хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан ахмад настнуудыг дарамтлах, хүчирхийлэх явдал Монголын нийгэмд хэр байгааг тодруулах явдал байлаа. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд, ахмад настнууд маань гэр бүл дотроо дарамтлал, хүчирхийлэлд өртөж, хүний үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байгаа нь батлагдаж байна. Монголын нийгэмд анхаарал татаж буй ажилгүйдэл, ядуурал, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хүрэлцээгүй байдал, архидалт зэрэг асуудал нь ахмад настнуудад дарамт бэрхшээл учруулж буй гол шалтгаан нь болж байна.

Судалгааны Үндэслэл

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв (ХЭҮТ), Монголын Ахмадын Холбооноос зохион байгуулдаг семинар, сургалт, ярилцлагууд дээр настайчуудыг дарамтлах, хүчирхийлэх явдал гарч байгаа талаар тодорхой баримт бүхий санал, шүүмжлэлүүд ялангуяа сүүлийн 2 жилд нилээд гарах болсон юм.

2002 онд нэр бүхий 20 ахмад настан дээрх 2 байгууллагад хандаж “Настайчуудын эсрэг гарч буй хүчирхийлэлтэй тэмцэх хууль” гаргах хүсэлт тавьсан захидал ирүүлсэн ба мөн ийм захидлыг Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яаманд өгсөн байлаа.

Гэр бүлдээ хүчирхийлэл, дарамтлалд өртөж ХЭҮТ-д хандан зөвлөмж туслалцаа хүссэн, хамгаалах байраар үйлчлүүлж буй настнуудын тоо нэмэгдэх хандлагатай байна. Энэ бүгд судалгаа явуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулсан юм.

Судалгааны зорилго

“Гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн төслийг 2003 онд УИХ-аар хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан ахмад настнуудыг дарамтлах, хүчирхийлэх явдал Монголын нийгэмд хэр байгааг тодруулах, мөн уг асуудалд олон нийтийн болон шийдвэр гаргагчдын анхаарлыг төвлөрүүлэхэд судалгааны зорилго оршсон болно.

Хамарсан хүрээ

Судалгаанд Улаанбаатар хотын 7 дүүрэг (Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Багануур), Төв аймгийн төвийн бүгд 1000 ахмад настан хамрагдсан. Нэг дүүрэг, аймгаас тус бүр 105-138 хүн хамрагдсан ба нийт 1000 хүн гэдэг нь 2000 оны хүн ам, орон сууцны улсын тооллогоор тоолуулсан нийт өндөр настны 0.5 хувьтай тэнцэж байгаа тул түүврийн бүтцийн хувьд хангалттай төлөөлөл юм.

Судалгааны аргачлал


Судалгаанд нийгмийн судалгааны асуулгын арга (анкет) болон чанарын судалгааны үндсэн аргуудын нэг болох ганцаарчилсан ярилцлагын аргыг хослуулан хэрэглэлээ.

Судалгаанд оролцогчдын шинж байдал

Судалгаанд 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдийг хамруулсан ба 52.9 хувь нь эмэгтэйчүүд, 47.1 хувь нь эрэгтэйчүүд байлаа.

Гэрлэлтийн байдлыг авч үзвэл 53.3 хувь нь гэр бүлтэй, 33.4 хувь нь бэлэвсэн хүмүүс байна. Давхардсан тоогоор, судалгаанд оролцогчдын гуравны хоёр нь буюу 73.9 хувь нь хүүхдүүдтэйгаа амьдардаг, 11.7 хувь нь хүргэнтэйгээ, 12.6 хувь нь бэр, 34.5 хувь нь ач, 26.5 хувь нь зээтэйгээ амьдардаг хүмүүс байлаа.


Хариулагчдын дийлэнх нь тэтгэвэрт гарсан хүмүүс байсан ба тэдний эдийн засгийн чадавхийн байдлыг авч үзвэл, өрхийн орлогынх нь ихэнхийг буюу 75.0 хувийг тэтгэвэр эзэлж байна (Зураг 1). Судалгаанд оролцогчдын 41.7 хувь нь өрхийн орлогыг үндсэндээ би өөрөө олдог гэж хариулж байв.



Гэр бүл дэх дарамтлал, хүчирхийлэл

Судалгааны дүнгээс үзэхэд ахмад настнууд үндсэндээ гэр бүлдээ дарамтлал, хүчирхийлэлд өртөж байна. Нөгөө талаар тэдний үзэж байгаагаар нийгмийн зүгээс дарамт учруулж буй асуудлууд ч цөөнгүй байна.

Ахмад настнуудыг элдэв хэлбэрээр дарамтлан хүчирхийлэх явдал голдуу гэр бүлийн хүрээнд гарч байна гэж судалгаанд хамрагдсан настайчуудын 67.8 хувь нь үзэж байгаа юм. Ахмад настангуудын 25 хувь нь буюу дөрвөн хүн тутмын нэг нь гэр бүлдээ дарамтлагдаж, хүчирхийлэгдэж байна гэж хариуллаа. Ялангуяа настайчуудыг сэтгэл санаагаар дарамтлан хүчирхийлэх явдал түгээмэл байна гэж тэдний 63.2 хувь нь үзэж байна (Зураг 2).



Сэтгэл санаагаар дарамтлах нь гол төлөв ахмад хүмүүсийг өндөр настай боллоо гэж ад үзэж, хэл амаар доромжлох, үзэл бодлоор нь гадуурхах, тайван байдлыг нь алдагдуулж, айлган сүрдүүлэх, элдэв шахалт үзүүлэх, ганцаардуулах, асрамж халамжгүй орших, хөөж туух зэрэг үйлдлээр илэрч байгаа нь судалгаанаас харагдсан юм.

Бодит баримт:

- *Чи бидэнд хэрэггүй, чиний үе өнгөрсөн, чи үхвэл таарна гэдэг, (СХД, 68 настай, эмэгтэй).*
- *Ач, зээ нар тоож үздэггүй. Надад зурагт үзэх ч эрх байдаггүй, (Төв аймаг, 72 настай, эмэгтэй).*
- *Том хүү "... хөгшин буриад минь идэх юм, сонин авчир" гэж загнадаг. Шөнөжин тамхи баагиулж, архи ууж агсам тавьдаг, (ЧД, 82 настай ахмад дайчин).*
- *Хүү найз охинтойгоо архи ууж, агсам тавьж зовоодог. Найз бүсгүй нь чиний ээж чинь худлаа өвддөг, үхдэггүй гэдэг. (БЗД, 74 настай, эмэгтэй).*
- *Архи уудаг хүргэн биднийг амраадаггүй, бүгдийг нь "шудаж өгнө" гэж загнадаг, (БЗД, 74 настай, эмэгтэй).*
- *Өргөмөл охинтой, нөхөр нь архи ууж, түүнийг зодож нүддэг, туж дарамттай. Элдэв хоёроор хэлж доромжилдог, 60 хүртлээ хүнээс, эцэг эх ханиасаа ч дуулж үзээгүй юмаа хүргэн, охиноосоо үзэж, сонсож байна, (БНД, 60 настай, эмэгтэй).*

Дээрхээс гадна, эрх мэдэл, эдийн засгийн шинжтэй дарамтлал, хүчирхийлэлд учирч байна гэж судалгаанд оролцогчдын 25.7 хувь хариулсан байна. Энэ хэлбэрийн дарамтлал нь настайчуудыг мөнгөө өөрсдөө зарцуулах эрх мэдэлгүй болгох, тэтгэврийн мөнгө, эд юмсыг нь хулгайлах, дур мэдэн зарж үрэх, орон байраар хавчих, орон сууцыг нь дураараа зарж, гэрээс нь хөөх, хоол хүнсээр гачигдуулах, ялгаварлах зэрэг хүчирхийллийн үйлдлээр илэрч байна.

Бодит баримт:


- Хүргэн тэтгэврийн мөнгийг минь аваад хүүхдийн хоолны мөнгө өгнө гээд архи уучихдаг, (БЗД, 67 настай).
- Үр хүүхэд, хүргэн бэрийн зүгээс “та бага тэтгэвэр авдаг хэрнээ үрлэг зарлага их гаргалаа” гэдэг, (БНД, 77 настай, эмэгтэй).
- Хажуу хашаанд маань амьдардаг айлын хүү аав, ээжийнхээ хашаа эзэмших эрхийн бичгийг хулгайлаад, тэр хашаанд амьдардаг 3 айл гурвуул адилхан бичигтэй болсон. Би шүүхэд ханддаг юм билүү, яахаа мэдэхээ болиод байна хэмээн эцэг нь ярьж байсан, (БЗД, 65 настай ахмад).

Судалгааны үед биеийн хүчний хүчирхийлэлд өртөж байгаа талаараа ганцаарчилсан ярилцлагын үеэр ахмадууд жишээ баримттайгаар ярьсан юм. Ийм хэлбэрийн хүчирхийлэлд өртөгчид судалгаанд оролцогчдын 14.3 хувийг эзэлж байна.

Бодит баримт:

- Манай хүү өвгөний толгойг хагалсан, миний гарыг хугалсан. Хүү ажил төрөл хийдэггүй, архи их уудаг. Би хүүдээ 2 удаа зодуулсан. Зодоон болоход хүүгийн эхнэр нь их уруу татдаг, хатгаж биднийг хооронд нь хэрэлдүүлж зодоон үүсгэдэг. Бас нөхөртөө худлаа хэлж миний юмыг авдаг. Ээмгийг маань ломбарданд тавьж заруулчихаад болохгүй болохоор нь нөхөртөө хэлж зодоон болгосон.
- Хүргэн бас архи ууж ирээд орон гэрээ буулгадаг, манай хажууд амьдардаг. Эхний үед салгах гэж ордог байсан. Сүүлдээ ч орохоо больсон. Охин их нуудаг. Архи уухын тоолонгоор авгайгаа зоддог. Манай охин галзуурахаас наагуур сэтгэлийн дарамтанд байдаг, (БЗД, 10-р хороо, 66 настай, эмэгтэй).
- Манай хорооны 70 настай эмээ хүүхдүүдээсээ айгаад бүр сүнс нь зайлдаг. Хүүхэд нь анх зодож бэртээсэн. Өөрөө ерөөсөө хэлдэггүй. Өнхөрч ойчоод гэмтсэн гэдэг. Эхийгээ асрана халамжилна гэсэн юм байхгүй. Тэтгэврийг нь аваад архи уудаг, эмнэлэгт хэвтэхэд нь нэг ч эргэж байгаагүй, (БЗД, 16-р хороо, Ахмадын хорооны дарга, 62 настай, эрэгтэй).

Ахмад настнуудын эсрэг доромжлол, хүчирхийллийг хэн үйлдэж байгааг судалж үзэхэд, настайчууд гэр бүлдээ өөрийн хамгийн ойр дотны хүмүүсийнхээ дарамтлал, хүчирхийлэлд өртдөг байна. Судалгаанд оролцогчдын 38.6 хувь нь хүүхдүүдийнхээ зүгээс учруулж буй хүчирхийлэл, дарамтанд өртдөг гэж хариулсан байв. Тэрчлэн гэр бүлийн гишүүдийн архи уудаг хэн нэгний болон хүргэн, бэрийн хүчирхийлэл, дарамтлалд өртөж хохирдог юм байна. Харин нэг гэр бүлийн хоёр ахмад настан бие биенийгээ дарамтлах нь бусад үзүүлэлтүүдээс харьцангуй бага харагдаж байвч эхнэрээс илүүтэйгээр нөхрийн зүгээс дарамтлах, хүчирхийлэх нь илүү байдаг байна (Зураг 3).




Гэр бүл дэх дарамтлал, хүчирхийллийг даван туулах боломж тун хязгаарлагдмал, бараг сонголтгүй шахам байна гэж ахмад настнууд үзэж байна. Тэд энэ явдлыг аль болохоор хүлцэн тэвчихийг эрмэлздэг байна. Тухайлбал судалгаанд оролцогчдын 42.8 хувь нь хувь заяандаа гомдож сэтгэл санааны хямрал дарамтанд орж, үхэх юмсан гэж боддог гэжээ. Ингэж хариулагчид гол төлөв хавь ойрын хөгшчүүлдээ ярьж, уйлж сэтгэлээ онгойлгодог, заримдаа яах ч арга ухаанаа олдоггүй байна. Түүнчлэн 20 хувь нь нуудаг, тэвчдэг, үр хүүхдийнхээ нэр төрийг боддог учраас хэн нэгнээс тусламж эрж хандаагүй байна. Харин хариулагчдын 11.6 хувь нь ийм тохиолдол байхгүй буюу миний амьдралд тохиолдож байгаагүй, 6.6 хувь нь цагдаагийн байгууллагад баривчлуулдаг, хороонд мэдэгддэг, 1.3 хувь нь үл тоодог гэжээ. Ер нь хууль цагдаагийн байгууллага уг асуудлыг шийдэхдээ удаан, арга хэмжээ авч чаддаггүй, харин ч дахин дарамтанд орно гэж хариулж байсан юм.

Бодит баримт:


- Хүү архи уудаг, өвчтэй эцгийгээ чи үхвэл таарна гэдэг, үхсэн ч би ажил хийхгүй гэж бид хоёрыг дарамталдаг байсан. Энэ байдлыг 10 жил тэвчсэн, бүр дийлэхээ байгаад цагдаад хандсан. Одоо Багахангайд архины хугацаагүй эмчилгээнд явуулсан. Архины эмчилгээнээс ирээд дахиад та нарыг дарамтлана гэдэг. Битгий эргэж ирээсэй л гэж бодож байна. Наана нь хүрч ирээд нөгөө байдал давтагдах болов уу хэмээн айж сууна, (БЗД, 70 настай, эмэгтэй).
- Хэнд ч, хаашаа ч ханддаггүй. Бараг дотны найздаа ч хэлдэггүй. Хэзээ амьсгал хураана, түүнтэйгээ л дуусна даа, (БЗД, 54 настай, эмэгтэй).
- Болох ёстой юм болж байгаа юм байлгүй гээд хувь заяатайгаа эвлэрээд сууж байдаг. Тэмцээд ч нэмэр алга, (ЧД, 71 настай, эрэгтэй).
- Хүүхдээсээ айгаад чимээгүй л байдаг. Архи уугаад намайг зодож, хөөнө, гудамжинд, орцонд ч хонодог. Хөгшин болоод хүний тооноос хасагдаж байна даа. Батсүмбэрийн асрамжийн газар очмоор байна. Даан ч өвчтэй (бөөрний дутагдал) гээд аваагүй, (БГД, 85 настай, эрэгтэй, өргөмөл хүүгийн дээ амьдардаг).
- Шүүх, сэргийлэх их хүнд сурталтай, тоодоггүй болохоор нэмэргүй, (СБД, 61 настай, эрэгтэй).

Ахмад настнууд хүчирхийлэл, дарамтлалд өртсөн үедээ цагдаад бараг ханддаггүй байна. Судалгаанд оролцсон, хүчирхийлэлд өртөж байсан ахмадуудын 83.1 хувь нь хуулийн байгууллагад ханддаггүй бөгөөд зөвхөн 16.9 хувь нь цагдаагийн байгууллагад хандаж байжээ. Цагдаагийн байгууллагад хандсан ахмадуудын 3.1 хувь нь авч байсан туслалцаандаа сэтгэл хангалуун, 13.8 хувь нь сэтгэл хангалуун бус гэж хариулсан байна (Зураг 4).



Цагдаа, хуулийн байгууллагад ханддаггүй гол шалтгаан нь амадууд хүүхдүүдийнхээ нэр төрийг боддог, авч буй арга хэмжээ үр нөлөө муутай, цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийг тухайн гэр бүлийн дотоод асуудал гэж үзэх нь олонтаа байдагтай холбоотой гэсэн хариултууд өгчээ (Зураг 5).

Зураг 5. Дарамтлал хүчирхийлэлд өртсөн боловч цагдаагийн байгууллагад ханддаггүй ахмадууд, шалтгаанаар



Ахмад настнуудын дунд хүчирхийлэл үйлдэгчдийг торгох, түр хугацаагаар баривчлах нь ямар ч үр дүнд хүрдэггүй, харин ч дахин уг үйлдлийг давтах сэдэлт нь болдог, засардаггүй, цагдаагийн байгууллагад хандсанаар эргээд өөрөө эдийн засгийн дарамтанд ордог гэсэн ойлголт, хандлага олон байлаа.

Ахмад настнууд хүчирхийллийг даван туулах боломж, түүнээс ангижрах асуудалд нэн болгоомжилсон, хязгаарлагдмал байр суурь баримталж буй нь судалгаанаас харагдаж байсан юм.


Ганцаарчилсан уулзалтын үеэр ч зарим настайчууд, ялангуяа орон сууцны маргаан, эцэг эхийнхээ байрыг зарсан, булаасан, эзэмших эрхийн бичгийг нь нууцаар авсан тохиолдолд хууль цагдаагийн байгууллага яах ч аргагүй юм байна гэх мэтээр шийдэж чаддаггүй, хохирогч болон гэр бүлийн төсвөөс торгуулийн мөнгө төлж байгаа явдал нь зарим тохиолдолд хохирогчийг гомдлоо буцаахад хүргэдэг тухай ярьж байлаа.

Бодит баримт:

- Цагдаа арга хэмжээ авч чаддаггүй, би өөрөө цуг торгуулдаг, баривчлууллаа гээд хүүхэд агсан тавьдаг, (ЧД, 70 настай, эрэгтэй).
- Нэг удаа баривчлаад засрахгүй, харин ч аллага гарч магадгүй, өширхдөг, (БНД, 58 настай, эмэгтэй).
- Нас ахисан болохоор хууль цагдаа гэж явахаасаа тээршаадаг. Нөгөө талдаа нэр хүндээ боддог. Хүүхэдтэйгээ маргах хаашаа ч юм бэ гэж боддог, (СХД, 61 настай, эмэгтэй).
- Хууль зүйн акт нь дутагдалтай учраас зохицуулах арга байхгүй, нэг талыг барьсан шийдвэр гаргадаг тал бий. Зарим тохиолдолд хуулийн байгууллагын ажилтнууд шудрага биш ажилладаг, мөнгө хахууль авдаг, танил тал хардаг, (БГД, 67 настай, эрэгтэй).
- Цагдаа хуулийн байгууллагад хэлээд бариулсан ч тэд эргээд тавиад явуулчихдаг учир бараг хэлж бариулж өш хонзон болсноос айж, ичээд дуугүй сууж байсан нь дээр, (СБД, 62 настай, эмэгтэй).
- Яаж хүмүүжүүлэх аргыг хайхардаггүй, зөвхөн эрүүлжүүлэхэд өгөх биш, жигшүүлж гэмшүүлэх, ажил хийлгэх хэрэгтэй байна. Жишээ нь пайз зүүлгээд байр тойруулж цэвэрлүүлэх, (БЗД, 65 настай, эрэгтэй).


Настайчуудыг элдэв хэлбэрээр дарамтлан хүчирхийлэхийг судалгаанд оролцогчдын 92 хувь нь гэмт хэрэг, 76 хувь нь нийгмийн тулгамдсан асуудал мөн гэж үзэж байна

Ахмад настнуудыг хүчирхийлэх нь гэмт хэрэг мөн гэж хариулсан хариулагчдыг боловсролын түвшнээр нь Зураг 6-д үзүүлэв.




Ахмад настнуудыг хүчирхийлэх нь гэмт хэрэг биш гэж үзсэн хариулагчид тун бага хувийг эзэлж байгаа бөгөөд тэдний үзэж буйгаар гэмт хэрэг бол өөр зүйл, сэтгэл санааны дарамтлал нь гэмт хэрэг биш, ахмадуудыг хүчирхийлж дарамтлахын эсрэг хууль байдаггүй тул гэмт хэрэг гэж үзэх үндэслэл болохгүй, гэр бүл дэх хүчирхийлэл нь гэр бүлийн асуудал учраас гэх зэргээр хариулсан байв.

Судалгаанаас харахад ахмадуудыг дарамтлан хүчирхийлдэг асуудлыг нийгмийн тулгамдсан асуудал гэж ихэнх нь үзэж байсан (Зураг 7) бөгөөд үүнийг хүйсийн ялгаатай байдлаар авч үзвэл: эрэгтэйчүүдийн 34.3 хувь, эмэгтэйчүүдийн 41.8 хувь нь ийнхүү хариулсан байна.



Дарамтлал, хүчирхийлэл нь нийгмийн тулгамдсан асуудал гэж хариулсныг насаар нь авч үзвэл 61-70 насны хариулагчид (33.8) бусад хариулагчдаас өндөр хувийг эзэлж байна.

Ахмад настнууд гэр бүлдээ дарамтлал хүчирхийлэлд өртөж байгаа явдалд эргэн тойрны хүмүүс хэрхэн хандаж байна гэсэн асуудлыг судалгаагаараа бид хөндсөн юм (Зураг 8).



Ахмад настнууд өөрсдийгөө хүчирхийлэлд өртөж байгаад нийгмийн шинжтэй олон асуудлууд нөлөөлж байна гэж үзэж байгаа бөгөөд их төлөв цалин, тэтгэвэр тэтгэмжийн үл хүрэлцээ, орон байр, түлээ нүүрс, үнийн өсөлт (цахилгаан дулааны үнэ), өмч хувьчлал, хүүхдийн сургалтын төлбөр, санхүү мөнгөний гачааллаас болж шаардлагатай эмчилгээ хийлгэж чаддаггүй тул эдийн засаг болон сэтгэл санааны дарамтанд орж, эрүүл мэндээрээ хохирдог гэжээ. Хүүхдүүд ажилгүй учир үргэлж сэтгэлийн дарамтанд байдаг гэх зэрэг мөнгөтэй холбоотой дарамт ахмад настнуудад хамгийн хүндээр тусч байгаа нь харагдлаа. Энэ бүгд нь 2001 онд явагдсан “Монгол Улс дахь Хүний Эрхийн Төлөв Байдал” судалгааны 5.5.1-д дурьдсанчлан ахмад настанд тохиолддог нийтлэг бэрхшээлүүд болох ихэнх ахмадуудын тэтгэвэр амьдралд хүрэлцэхгүй байгаа, өрхийн амьжиргааны түвшин доошлох тутам тэтгэвэр тэтгэмжээс хамаарах байдал ихэсдэг, ахмад настнуудад орлогоо нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байдаг, нийгмийн хамгаалал халамжийн үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй байгаа зэрэг дүгнэлтүүдийг дахин нотолж байна.

Ахмад настнууд дараах үзүүлэлтүүдийг нийгмийн шинжтэй дарамт бэрхшээл гэж үзсэн байна. Тухайлбал, 61.0 хувь нь эдийн засгийн дарамт буюу түлээ түлшний үнэ дийлдэхгүй, тэтгэвэр бага байна, 3 хүн тутмын нэг нь нийгэмд гарч буй сөрөг үзэгдлүүд болох архидалт, гэмт хэрэг, ажилгүйдэл, ядуурал нь ахмад настнуудын амьдрал ахуй, сэтгэл санаанд дарамт болдог гэж хариулжээ. Харин 32.8 хувь нь ахмадуудыг

үл хүндэтгэн хөдөлмөрийн насандаа байхад нь тэтгэвэрт гаргадаг, настны ажил амьдралын асар их туршлага, дадлага чадварыг ашиглахгүй байна гэж үзэж байна. Мөн 25.5 хувь нь архидалт, гэмт хэрэг, танхайрал, хуулиа дээдэлдэггүй дураараа дургигчид газар авч байгаа нь дарамт болж байна гэж хариуллаа.

Ахмад настнууд өөрсдөдөө учирч буй дарамт бэрхшээлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замын талаар дараах санал бодлоо илэрхийлж байна:

- Архидалттай шийдвэртэй тэмцэх, архи ууж согтууран, хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийг хатуу шийтгэж, нийгмээрээ жигшдэг уур амьсгал бий болгох;
- Ажилгүйдлийг бууруулах талаар төр засгаас тууштай, эрчимтэй үйл ажиллагаа явуулах;
- Судалгаанд оролцсон ахмадууд архидалт, ажилгүйдэл хоёрыг хүчирхийлэл, танхайралд нөлөөлж буй гол хүчин зүйл гэж үзсэн;
- Хуулийг боловсронгуй болгох. Хүн бүр хуульд захирагддаг нийгмийн орчин бүрдүүлэх, хуулийн байгууллагын ажилтнуудын ажил хэргийн мэдлэг, хариуцлага, санаачлагыг сайжруулах;
- Хууль сурталчилах ажлыг айл өрх, иргэн бүрт хүрч байхаар өргөн хүрээнд эрчимтэй шуурхай явуулдаг байх;
- Цагдаагийн байгууллага, иргэд, олон нийтийн хамтын ажиллагаа сайжруулах. Цагдаагийн хэсэг нь оршин суугчдынхаа дунд тэдэнд хамгийн ойр байрлаж, аюул тохиолдсон үед шуурхай арга хэмжээ авч байх, ялангуяа архиддаг, хүчирхийлэл үйлддэг айл өрхийн талаар нарийн бүртгэлтэй байж тийм гэр бүлийн настайчуудын аюулгүй байдалд зориуд анхаарч, эргэж тойрдог, байнгын холбоотой байх;
- Архичид, хүчирхийлэл үйлдэгчдийн оюун санаа нь нөлөөлөхүйц ганцаарчилсан хэлбэрийн ажлууд, сургалт зөвлөгөө зэрэг идэвхитэй арга хэлбэрийн чухалчилах;
- Ахмад ба өндөр настны нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг шинэчлэн боловсронгуй болгож, өөрийгөө хамгаалах, асрамжлах чадваргүй өндөр настнуудыг улсын асрамжинд авах, улсын асрамжийн орчин үеийн тохилог тав тухтай газруудыг олноор байгуулах;
- Настайчуудад зориулсан үйлчилгээний хотхон, хорооллуудыг барьж байгуулах зэрэг саналыг судалгаанд оролцогчид дэвшүүлсэн болно.

Дүгнэлт

Ахмад настнууд дарамтлал, хүчирхийлэлд хэр өртөж байгаа талаар 1000 ахмад настнуудын дунд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд: Монголын нийгэмд настайчууд гэр бүл дотроо дарамтлал, хүчирхийлэлд өртөж, хүний үндсэн эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байна. Түүнчлэн ажилгүйдэл, ядуурал, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн хүрэлцээгүй байдал, архидалт зэрэг ахмад настнуудын сэтгэл санааг зовоож, дарамт бэрхшээл болж байдаг нийгмийн шинжтэй асуудлууд цөөнгүй байна.

- Судалгаанд оролцсон 4 хүн тутмын нэг нь гэр бүлдээ хүчирхийлэл, дарамтлалтай учирч байна гэсэн дүн гарлаа.

- Гэр бүл дэх хүчирхийллийн олон хэлбэр, үйлдлүүдэд ахмад настнууд нэрвэгдэж байна. Тэдгээрийн дотроос сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох хэлбэр 63.2 хувийг эзэлж байна. Үндэсний Статистикийн газраас 2001 онд явуулсан судалгаагаар “Өндөр настны 80 гаруй хувь нь уйтгар гунигаасаа салж чаддаггүй” гэж хариулсан нь энэ байдалтай зарим талаараа холбоотой байж болох талтай юм.
- Гэр орныхны зүгээс эрх мэдэл, эдийн засгийн шинжтэй дарамт шахалт үзүүлдэг гэж судалгаанд оролцогчдын 25.7 хувь нь хариулсан байлаа.
- Зодож, цохиж, эрүүл мэндэд нь гэм хор учруулдаг үзүүлэлт 14.3 хувийг эзэлж байна.
- Настайчуудыг хүчирхийлж, дарамтлагч нь тэдний хамгийн ойрын хүн болох хүүхдүүд нь гэж судалгаанд оролцогчид хариулсан бөгөөд энэ үзүүлэлт 38.6 хувь байгаа нь анхаарал татаж байна.
- Ахмад настнууд өөрийн гэр бүл дотроо хүчирхийлэгдэж, дарамтлагдаж байгаа учир шалтгаанаа юу гэж үзэж байгаа тухайн асуултыг судалгаагаар тавьсан юм. Тэд гэр бүл дэх хүчирхийлэл, дарамтлалд гэр бүлийн гишүүд, хүүхдүүдийн хүмүүжил төлөвшил, зан араншин үзэл бодлын зөрөлдөөн нөлөөлж байна гэж үзэж байгаа хэдий ч энэхүү сөрөг үзэгдлийн үндсэн шалтгаан дотроосоо бус гадна орчноос ирж байна. Тухайлбал: ажилгүйдэл, ядуурал (43.7%), архидалттай (39.8%) холбон үзэж байна. Настайчуудын энэхүү дүгнэлт нь манай нийгмийн өнөөгийн байдал, бэрхшээлтэй холбогдон гарч ирж байгаа ба нөгөө талаар ахмад настнуудын олонхи нь мөнгө санхүү, орон байр, хоол хүнс, асрамж арчилгаа гээд өдөр тутмын наад захын хэрэгцээнээсээ эхлээд олон талаараа хүүхдүүд, гэр орныхноосоо шууд хамааралтай байдаг хөгшчүүлийн ахуй амьдралын онцлогтой холбоотой гэж үзэж байна. Тэрчлэн ахмад настнуудын дунд гэр бүл дэх хүчирхийллийн үндсэн шалтгаан, шинж төлөвийн талаар зөв ойлголт өгөх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг өргөн явуулах шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.
- Гэр бүл дэх дарамтлал хүчирхийллээс хэрхэн гарах, даван туулах талаар настайчууд ихэнхдээ сонголтгүй мухардмал байдалд орж байна.

Ахмад настнуудын хариултуудаас үзэхэд тэд хүчирхийлэгдэж, дарамтлагдаж байгаа байдлаа нууж тэвчин, хувь заяандаа гомдож, сэтгэл санаагаар хямарч, айж түгшин, яах ч учраа олохгүй цөхөрдөг. Зарим үед ингэж амьд яваад яахав гэдэг бодолд автагддаг явдал ч гардаг байна.

Эдгээр байдлын учир шалтгааныг судалгаа явуулсан баг дараах үндэслэлээр тайлбарлаж байна.

- “Үхтэл үр харам” гэдэг үзэл хандлага настай хүмүүсийн дунд харьцангуй хүчтэй уламжлагдаж ёс мэт мөрдөгдөж ирсэн явдал үүнд нөлөөлж байна.
- Настайчууд ихэнхдээ сэтгэлээ хуваалцах ойр дотны нөхөд цөөнтэй, ганцаардмал байдалд байх нь олонтаа.
- Судалгаанд оролцсон настайчуудын 83.1 хувь нь хүчирхийлэл дарамтанд өртсөн үедээ цагдаа, хуулийн байгууллагад ханддаггүй.

Учир нь юуны түрүүнд үр хүүхдүүд, гэр бүлийнхээ нэр төрийг боддог. Цагдаа асуудлыг шийдэхээсээ илүү харин ч төлбөр нэхэж нэмэлт дарамт болдог. Гэр бүлийн дотоодын хэрэг гэж үзээд асуудлыг тоож үздэггүй байна.

Энэ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан сэргийлэх эрх зүйн үндсийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

- Ахмад настнууд гэр бүлдээ дарамтлал, хүчирхийлэлтэй учирч байгаа нь зөвхөн хувь хүн тухайн гэр бүлийн асуудал төдийгүй нийгмийн шинжтэй олон сөрөг үр дагавар авчрах улс орны өнөө, ирээдүйн хөгжилд, залуу үеийн хүмүүжил төлөвшил, хүн ардын амгалан тайван байдал, эрүүл мэндэд хортой нөлөөлөх ноцтой асуудал гэж судалгаанд оролцсон настайчууд үзэж байна.
- Настайчуудыг элдвээр дарамталж хүчирхийлж байгаа нь нийгмийн анхааралд байх ёстой тулгамдсан асуудал гэж судалгаанд оролцогчдын 2/3 нь үзсэн байхад 92 хувь нь энэ бол гэмт хэрэг гэж үзсэн байна.
- Ахмад настнууд гэр бүлдээ хүчирхийлэл дарамтанд өртөж байгаа явдлыг эргэн тойрны хүмүүс нь голдуу тэдний заяа төөрөг нь, амьдралд байдаг л хэвийн нэг үзэгдэл гэж үзэх буюу өрөвдөхөөс цаашгүй байдлаар ханддаг нь судалгаанаас харагдлаа. Энэ нь гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нийгэм олон нийтэд түшиглэсэн их ажил хийх хэрэгтэйг харуулж байна.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудаас энэ чиглэлээр явуулж буй ажлын далайц, хүртээмж хангалтгүй, ялангуяа ахмад настнуудад мэдээлэл, сургалт сурталчилгаа хүрч чадахгүй байгааг илтгэж байна.

“Ахмад настнуудад учирч буй дарамтлал, хүчирхийлэл” судалгаа нь уг сэдвээр явуулсан анхны судалгаа юм. Цаашид нарийвчилсан, өргөн хүрээг хамарсан томоохон судалгаа явуулах шаардлагатай байна.

Бодлогын зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

А.Төрийн бодлогын түвшинд:

- Настайчуудад гэр бүл дэх хүчирхийллийг даван туулах боломж хязгаарлагдмал байгаа нь судалгаагаар тодорхой харагдсан тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар бие даасан хууль гаргаж, уг хуулинд настайчуудыг дарамтлал, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах тодорхой заалт оруулах;
- Ахмад настнуудын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн, нийгэм олон нийтэд тулгуурласан халамж үйлчилгээний тогтолцоог улсын хэмжээнд бий болгох;
- “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрт нэмэлт баяжилт хийх, ахмад настнуудыг гэр бүл дэх болон гэр бүлээс гадуурх хүчирхийлэл дарамтлалаас урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдөд туслан, үйлчлэх сургалт, сурталчилгаа, судалгаа явуулах зэрэг асуудлуудыг тусгасан үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

- Настнуудад зориулсан асрамжийн газар болон орон сууцны хороолол барих төсөл хэрэгжүүлэх. Энэ нь манай судалгаанд оролцсон ахмад настнуудын нэлээдгүй хэсгийн санал байсныг тэмдэглэж байна.
- Архидалттай тэмцэх ажлыг улам эрчимтэй явуулах;
- Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, бууруулах урьдчилан сэргийлэхэд хууль цагдаагийн байгууллагын ажилтнуудын ойлголт мэдлэг, хандлагыг шинэчлэн өөрчлөх. Хууль цагдаагийн байгууллагад гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх асуудал хариуцсан мэргэшсэн алба байгуулах;
- Төрөөс хөдөлмөрийн чадвар бүхий ахмад настнуудыг богиносгосон цагаар ажиллах боломжоор хангах, тэдний ажлын туршлага, мэдлэгийг ашиглах арга замуудыг хайж нэвтрүүлэх;

Б. Мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын түвшинд:

- Настайчуудад зориулж сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох;
- Гэр бүлийн хүрээнд хүмүүнлэг, оюунлаг сургалтыг тасралтгүй явуулах. Настнуудыг хүндэтгэх, харилцан ойлголцох дадлыг эзэмшүүлэх, нийгмийн ёс суртахууны сургалтыг хүүхэд залуучуудын дунд явуулах. Сургалт, сурталчилгааг явуулахдаа өрхөөс өрхөд гэж хандах. Урлаг, соёлын байгууллагуудтай хамтран ажиллах;
- Найстайчуудыг сэтгэл санаагаар дэмжих, сонирхлын болон зуучлалын клубууд, зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулах. Чөлөөт цагийн сонирхолтой арга хэмжээнүүдийг оршин сууж байгаа газруудаар нь зохион байгуулах;
- Ахмад настнуудтай ажиллах нийгмийн ажилтнуудыг бэлтгэж гаргах;
- Сайн дурынхны хөдөлгөөн өрнүүлэх;

В. Хүчирхийлэл, дарамтлал үйлдэгчдэд чиглэсэн үйл ажиллагаа:

- Эдгээр хүмүүст зориулсан сургалт, сурталчилгаа, ёс зүйн хичээлийг анхан шатны нэгж хороо, нийгмийн ажилтнуудын хамтын оролцоотойгоор явуулж хэвших, хүчирхийлэл үйлдэгчдийн ухамсар зан үйлд нөлөөлөх ажлыг үр өгөөжтэй олон хэлбэрүүдээр зохион байгуулах;
- Настайчуудын эрхийг баталгаажуулахад төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийг хөгжүүлэх;